

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**

**Өдөр +20**  
**Шөнө +13**

**УЛС ТӨР**

**Б.ПҮРЭВДОРЖ: УЧРАА ОЛОХГҮЙ БАЦААНУУД ТӨРИЙН ХУУЛИЙГ САМАРЧ БАЙНА**

**II нүүрт**

**ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ**

**ЦАХИЛГААНЫ ШӨНИЙН ТАРИФЫГ НИЙСЛЭЛД 100, ОРОН НУТАГТ 50 ХУВЬ ХӨНГӨЛНӨ**

**IV нүүрт**

Дугаарын **60** мөр

Дахин санал хураалтдаа идэвхтэй оролцоорой

## ХАЙРАН НЭР ХҮНД...

**Н.ПУНЦАГБОЛД**

Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн дахин санал хураалт маргааш болно. Монгол Улсын түүхэнд анх удаагаа болж буй зүйл. Тийм болохоор хүмүүс бага ойлголттойн дээр дахин санал хураалтад жаахан хойрго хандах магадлал өндөр байна. Ядаж байхад ярь гэжээр цагаан санал өг гэж уриалах бүхэл бүтэн нам, хэсэг бүлэг этгээд гараад ирчихлээ. Тэд цагаан санал өгснөөр намууд ялахгүй, ард түмэн ялах учиртай. Тэдэнд сануулга өгье гэх мэт зүйлийг ярьж байна. Бүр улаан цагаандаа гараад нэр хүндтэй, олны танил болсон хэний ч хамаагүй зургийг тавьж, "Цагаан санал" гэсэн уриалга гаргаж ч байх шиг. Арай л гадаадын кино жүжигчид, дуучдын зургийг тавих нь холгүй байна. Энэ бүгдэд автаж буй залуучууд ч цөөнгүй байгаа.

**О.УЯНГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль энэ өдрүүдэд үргэлжилсээр байгаа. Маргааш сонгуулийн дахин санал хураалт болно. Тэгвэл энэ том үйл явдлын хажуугаар нэгэн дуулиант хэрэг үүсээд байгаа нь УИХ-ын хамгийн залуу гишүүн болох Д.Гантулгын холбогдсон хүчингийн хэрэг. Энэхэрэг зургадугаар сарын 12-ны өглөө болсон талаар хохирогч гэгдээд буй талаас мэдээлээд байгаа. Хэргийн талаар "Zuv.mn" гэдэг сайт дээр мэдээлэл гарсан гэдэг. Гэвч мэдээллийг утгасан гэж яриад буй. Мөн маш олон хэвлэл мэдээллийнхэн УИХ-ын гишүүн хэрэг хийсэн гэж мэдээлж байлаа. Харин хэрэгт холбогдсон гэх Д.Гантулга гишүүн одоо болтол албан ёсоор ямар нэг тайлбар хийгээгүй. Нэг сайтад ярилцлага өгч "Сонгууль дууссаны дараа гүтгэлэг дуусах байлгүй дээ. Сошиалаар тарааж байгаа бичлэг дээр тэр хүн цаашаа хараад суучихсан, хоолойны өнгийг нь өөрчилсөн, нэр ус нь тодорхойгүй байдаг. Бичлэгийг анх 30, 40 дагагчтай хуурамч хаягнаас

зохион байгуулалттай тараасан байгаа юм. Тэр хаягийг нь цагдаагийн байгууллагаар шалгуулж байгаа. Би "Намайг гүтгээд байна" гэж хэлэх биш гүтгэлэг гэдгийг нь баримттайгаар дэлгэнэ. Одоохондоо тэр эзэн биегүй хаягны асуудал ойлгомжгүй байгаа тул цаг хугацаа хэрэгтэй байгаа. Хүмүүс эргэлзэж байгаа байх. Зарим нь гүтгэлэг гэж байгаа. Зарим нь болохоор Д.Гантулга "Залуу хүн юм чинь магадгүй" гэсэн бодолтой байгаа. Ийм үед би гарч ирээд "Гүтгэлэг байна" гэж ярихаар хэн итгэх вэ дээ. Цаад хүмүүс нь итгүүлэхгүй байхын төлөө ажиллана. Тэгэхээр хаяг нээсэн эзнийг олж, гүтгэлэг гэдгийг нь баримттайгаар нотолно" хэмээн ярьсан. Түүнээс хойш энэ хэрэг маш их улстөржиж, АН-ын зүгээс санаатай зохион байгуулж байгаа үйлдэл мэтээр тайлбарлаж эхэлсэн. Мөн эрхэм гишүүн өөрийнх нь нэр төрд халдсан мэтээр өдийг хүртэл тайлбарлаж буй. Ингэж байтал хохирогч талынхан мэдээлэл хийж, чухам юу болсон талаар ярьсан.



## "ЯАХ ВЭ ДЭЭ" АНГИЛЛЫН ТҮШЭЭ

**Ч.ЧУЛУУН**

"Хэн нь хэн бэ" булангийнхаа өмнөх дугааруудаас УИХ-ын гишүүдийн хэн нь хэн бэ, өмнө нь хэн байв, одоо хэн болов, юу хийж байна, сонгогчдын итгэл найдварыг дааж чадах төрийн түшээ мөн үү гэдгийг тольдон уншигчиддаа мэдээлж байгаа билээ. Өмнөх дугаартаа УИХ-ын сонгуулийн 1-14 дүгээр тойргийн гишүүдийг онцолж, нэр дэвшигчийн намтар, хувь хүнийхээ

хувьд хэн болох, цаашлаад төр түших ажлаа хэрхэн нэр хүндтэй хийж буйг нь уншигчиддаа хүргэсэн. Тэгвэл энэ удаагийн дугаарт, УИХ-ын сонгуулийн 15 дугаар тойрог болох Дорнод аймгаас УИХ-ын гишүүнээр томилогдсон УИХ, Засгийн газрын гишүүн Н.Номтойбаярыг дангаар нь онцолсон. Энэ удаад мөн энэ тойргоос УИХ-д сууж буй төрийн түшээ болох УИХ-ын гишүүн Ц.Болорчулууныг онцлолоо.

**Ж.ТЭМҮҮЛЭЛ: Бид олон зүйлээр анхдагч болсон үндэсний компани**

**Г.ГАНЧИМЭГ**

Социализмын үеийн үйлдвэрийг хувьчлал нэрээр аваагүй бүхнийг өөрийн гараар бий болгож, бүхэл бүтэн үндэсний үйлдвэрийг босгосон "Монфрэнс сүү" компанийн гүйцэтгэх захирал Ж.Тэмүүлэлийг "Би Монголоо ингэж хөгжүүлнэ" буланд уриалаа. "Монфрэнс сүү" компани дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангахаас гадна бүтээгдэхүүнээ экспортод гаргах оролдлогыг хийгээд эхэлчихсэн амжилттай яваа манай цөөн хэдэн үйлдвэрийн нэг юм.



**ДЭЛХИЙ ОХУ, БНХАУ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨНДӨР ТӨВШИНД ХҮРСНИЙГ ОНЦЛОВ**

**Б.ДАВАА**

БНХАУ-ын дарга Ши Жиньпин ОХУ-д айлчиллаа. 2017 он гарснаас хойш хоёр улсын төрийн тэргүүнүүд гурав дахь удаагаа уулзсан нь энэ. Сар хүрэхгүй хугацааны өмнө Ши, Путин нар Казахстаны нийслэл Астанад болж өнгөрсөн Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын дээд хэмжээний уулзалтын үеэр уулзжээ. Мөн үүнээс өмнө тэд тавдугаар сард Бээжинд болсон "Нэг зам, Нэг бүс" төслийн форумын үеэр уулзсан юм. Харин тэдний гурав дахь удаагийн

уулзалт Кремлийн ордонд боллоо. Хоёр орны тэргүүн тэргүүн хоёр талт уулзалт хийж, улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн салбарт хамтран ажиллах тухай хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зуржээ. Үүний дараа хоёр талын хамтын ажиллагаа өндөр төвшинд хүрснийг онцлон тэмдэглэсэн байна. Ерөнхийлөгч В.Путин "Орос-Хятадын түншлэлийн харилцаа бэхжиж, улам эрчимтэй хөгжсөөр байгааг" онцолсон бол Хятадын удирдагч Ши Жиньпин "дэлхий дахин дахь нөхцөл байдлаас үл хамааран хоёр орны харилцаа гуйвалтгүй тууштай хэвээр байна" хэмээжээ.

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк							
	Авах	Зарах		Авах	Зарах	Авах	Зарах				
АМ.ДОЛЛАР	2372.00	2394.00	ФУНТ	3032.00	3135.00	АМ.ДОЛЛАР	2375.00	2399.00	ФУНТ	3041.00	3141.00
ЕВРО	2675.00	2739.00	РУБЛЬ	39.20	41.20	ЕВРО	2670.00	2758.00	РУБЛЬ	39.06	42.23
ИЕН	20.80	21.41	ЮАНЬ	348.00	353.50	ИЕН	20.75	21.47	ЮАНЬ	348.00	354.40

## УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Зөөврийн хайрцагар өнөөдөр санал авна

Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн дахин санал хураалтыг орон даяар маргааш явуулахаар болсон. Энэ дагуу өнөөдөр СЕХ-ноос зөөврийн битүүмжилсэн хайрцагар өгөх саналыг авахаар болжээ. Сонгуулийн тухай хуулийн дагуу, эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй болон захиргааны зөрчлийн

улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан, цагдан хоригдсон, Дайчилгааны тухай хуулиар нийтийн дайчилгаанд хамрагдсан иргэд ийнхүү зөөврийн битүүмжилсэн хайрцагар саналаа өгөх эрхтэй юм. Харин гадаадад байгаа иргэд саналаа энэ сарын 04-нөөс эхэлж өгсөн бөгөөд санал авах хугацаа очигдөр 22.00 цагт дууслаа.

БАЙНГЫН ХОРОО

## Б.ПҮРЭВДОРЖ: УЧРАА ОЛОХГҮЙ БАЦААНУУД ТӨРИЙН ХУУЛИЙГ САМАРЧ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ЭРХЭС

УИХ-ын НББСПУ-ы өчигдрийн хуралдаанаар өнгөрөгч оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон бусад хуулийн төслүүдийг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдааныг УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл даргалан явуулсан юм. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Ерөнхий аудиторын орлогч С.Оюунбилэг танилцууллаа. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан УИХ-ын гишүүн Б.Саранчимэг асуулт асуусан юм. Тэрбээр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилгын үлдэгдэл төсөв Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төсөлд суусан эсэх, Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийг хэзээ ашиглалтад оруулах гэж байгаа талаар тодруулж харилт авсан бөгөөд 2016 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа,

татварын хөнгөлөлт үзүүлэх, улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон цэцэрлэгийг буулгаж, газрын байршил, зориулалтыг өөрчлөхгүйгээр шинээр барих талаар тусгажээ. Өчигдрийн хуралдаанаар Багшийн хөгжлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх хэлэлцэх байсан ч АН-ын бүлэг завсарлага авсан. Тэгвэл энэ асуудалтай холбоотойгоор УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж байр сууриа илэрхийллээ. Тэрбээр “Багшийн хөгжлийн төв”-ийг зарим сумдад байгуулчихсан байгаа. Гэтэл Багшийн хөгжлийн тухай хуулийн төсөлд “Багшийн хөгжлийн төв”-өөс өөр шинэ зүйл ганц ч алга. Мөн дээр үеийн ногоон малгайтнуудын “Ёс зүйн хороо” гэдгийг байгуулахаар болсон байна. Өөрөөр хэлбэл, аль нэг сургуулийн захирал өөртөө таалагддаг хэдэн нөхдүүдийг цуглуулж байгаад үзэл бодол, санаа нийлдэггүй багш нарыгаа ялладаг болох гэж байна. Намын томиллолтоор ирсэн багш намын үзэл бодолтой багшийг ажлаас нь чөлөөлөх тэр боломжийг нь энэ “Ёс зүйн хороо” гэдэгт олгочихсон байна. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийн багшийг өмчийн хэлбэр үл харгалзан төсвийн хөрөнгөөр таван жил тутамд мэргэжил дээшлүүлэх тэр заалтыг Боловсролын хуулиас авч хаясан байгаа. Өөрөөр хэлбэл, Ховдын сургуулийн багш энд ирээд Дорнодын багштай туршлага солилцох арга хэрэгслийг бүгдийг нь байхгүй болгочихсон гэсэн

## Өөрсдөө бичлэгээ алдчихаад АН-ыг буруутгаж болохгүй гэв



АН-аас цаг үеийн асуудлаар очигдөр мэдээлэл хийлээ. Тодруулбал тус намын дарга С.Эрдэнэ тэргүүтэй албаны хүмүүс сонгуулийн мэтгэлцээний бичлэгтэй холбогдуулан мэдээлэл хийв. Энэ үеэр тус намын дарга С.Эрдэнэ “Бид МАН-ын мэтгэлцээний бичлэгийн үеийн бичлэгийг хийгээгүй. МАН-ын дотроос шударга гишүүд гаргаж тавьсан байх. Ямар нэг сахилга хариуцлагаа өөрсдөө барьж чадаагүй хэрнээ өрсөлдөгч нам руугаа бухаж болохгүй.

Мэтгэлцээн бол жүжиг байсан. Бүх асуултуудыг урьдчилж бэлтгэсэн байсан шүү. Энэ бол монгол төрийн эрх мэдлийг хууль бусаар зохион байгуулалттайгаар авах гэсэн нэг хэлбэр. Аархал нэртэй нэвтрүүлгийг чөлөөт уран бүтээлчид хийсэн. Манай намтай ямар ч хамаагүй гэдгийг АН-ын даргын хувьд хэлж байна. 60 тэрбумын асуудал нэг газар нэг цагт бичигдсэн байна гэдгийг АНУ-ын шинжээчид тогтоосон. Шаардлагатай гэвэл шалгадаг, тогтоодог байгууллагад нь өгч шалгуулахад бэлэн байна. Ичгүүрсонжуургүй 60 тэрбумын бичлэгийг эвлүүлэг гээд зогсч байгаа хүн шударга байж чадах уу. Энэ бичлэгийг шалгах талаар хууль хяналтын байгууллага ямар ч үйлдэл хийхгүй байна. Тэд өнөөдөр Монгол төрийг худалдан авах ажлыг мэдсэн ч мэдээгүй юм шиг дуугүй байгаа. Би 2010 онд санаачлаад төрийн эрхийг хууль бусаар зохион байгуулалттайгаар авах нь төрийн эрхийн ноцтой зөрчсөн үйлдэл гэсэн заалт оруулж УИХ-ын гишүүний хувиар батлуулсан. 60 тэрбумын баримт эвлүүлэг байсан гэвэл нотол. Эвлүүлэг байсан гэдэг ганц үгээр бүх зүйлийг хаах гэж оролдож байгаа нь эмгэнэлтэй” гэв.

...Мөн дээр үеийн ногоон малгайтнуудын “Ёс зүйн хороо” гэдгийг байгуулахаар болсон байна. Өөрөөр хэлбэл, аль нэг сургуулийн захирал өөртөө таалагддаг хэдэн нөхдүүдийг цуглуулж байгаад үзэл бодол, санаа нийлдэггүй багш нарыгаа ялладаг болох гэж байна...

зөрчил гаргасан төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох хэрэгтэй гэв. Хуралдаанаар үргэлжлүүлэн Биений тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Мөн энэ өдрийн хуралдаанаар Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэн баталлаа. Уг тогтоолд нийслэлийн цэцэрлэгтэй 25 хороонд цэцэрлэг барих асуудлыг 2017-2019 онд үе шаттай шийдвэрлэх, нийслэлийн 75 цэцэрлэг, хөдөө орон нутгийн нэн шаардлагатай цэцэрлэгт өргөтгөл хийх, хувийн хэвшлийн болон байгууллагын цэцэрлэгийг барих санаачлагыг дэмжиж, урт хугацаатай бага хүүтэй зээл олгох,

MINFO

## МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:

С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ  
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Э.ЭНХЦЭЦЭГ  
90873012

Ахлах редактор:

Б.ӨНӨРТОГТОХ  
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба

Н.ПУНЦАГБОЛД  
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:

Б.ӨНӨРТОГТОХ  
88006842

Гэрэл зургийн алба:

Г.АРГУУЖИН  
96017873

Компьютерийн алба:

Б.ГАНЗОРИГ  
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:

Н.АЛТАНЦЭЦЭГ  
99173710

Захиалга, борлуулалтын алба:

М.ДАВААДУЛАМ  
99042510Э.САЙНЗАЯА  
99197866

Дугаарыг эрхлэсэн

Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг:  
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.  
2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.



## Цагаан хуудас уриалагчид бусдын нэр хүндэд халдсан уу

МАХН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшин өрсөлдсөн УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар эхний шатны сонгуульд иргэдийн 30 хувийн саналыг авч, жагсаалтын гуравдугаарт бичигдсэн билээ. Гэсэн ч С.Ганбаатар гуравдугаарт орсныгоо луйвар хэмээж “МАН-ын нэр дэвшигч М.Энхболд болон Х.Баттулга нар миний саналыг луйвардлаа би Ерөнхийлөгч болох байсан” хэмээн эсэргүүцэхээ илэрхийлсэн. Улмаар дахин санал хураалтыг хүчингүй болгохыг иргэдэд уриалж эхэлсэн юм. Тэгвэл С.Ганбаатарыг дэмжигчид сүүлдээ оюуны өмчийн хулгай хийж эхлэв бололтой. Тодруулбал, монголын залуу үеийн шилдэг төлөөлөл болсон урлаг, спортын олны танил залуусыг зургийг ашиглан “Залуусаа цагаан сонголт хийцгээе. Миний сонголт бол цагаан сонголт



гэх” постерийг цахим орчинд тарааж эхэлсэн юм. Тэгвэл энэ асуудлаар урлаг, спортын төлөөллүүд эхнээсээ байр сууриа илэрхийлж шүүхэд хандахаа мэдэгджээ. “Эмоци” продакшны жүжигчин Л.Сөрөлт энэ талаар цахим хуудсанд “Энэ юу вэ???” Болноч ээ. Миний зургийг зөвшөөрөлгүйгээр улс төрийн хар бараанд сөрөг зүйлд яагаад дур мэдэн ашиглаж байгаа юм бэ. Зохих газраар нь шалгуулж нэр төрөө сэргээнэ. Сонгуулиа идэвхтэй өгч иргэний үүргээ биелүүлээрэй ахан дүүс минь

ээ” хэмээн жиргэжээ. Мөн Их аварга Д.Дагвадорж зургийг нь зөвшөөрөлгүй ашиглан гүүтэж байна хэмээн мэдэгдсэн бол “Яг түүн шиг” шуоны шилдэг оролцогч С.Гантоого ч энэ асуудлыг зүгээр орхихгүй гэдгээ мэдэгдэв. С.Ганбаатарыг дэмжигчид Киви хамтлаг, дуучин Ану, жүжигчин Б.Мишээл, О.Долгөөн, дуучин Д.Төрмандах, Э.Чулуунчимэг зэрэг маш олон хүмүүсийн зургийг зөвшөөрөлгүй ашигласан нь тодорхой болоод байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## “Хүндэт өргөмжлөл”-ийг нэр бүхий иргэдэд гардуулав

Ажил үйлээрээ бусдыгаа манлайлсан нэр бүхий хүмүүст Засгийн газар Үндэсний их баяр наадмын өмнө “Хүндэт өргөмжлөл”-өө хүртээдэг билээ. Энэ уламжлалын дагуу өчигдөр Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат тэргүүтэй Засгийн газрын гишүүд Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн танхимд уг шагналыг гардууллаа. Тухайлбал, хүндэт өргөмжлөлөөр Стандартчилал, хэмжил зүйн газрын жолооч Л.Лхагвасүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, “Их нигүүсэл” ТББ-ын тэргүүн М.Сарнай нарын 10 гаруй иргэнийг шагналаа. Шагналыг гардуулсны дараа Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат хэлэхдээ “Салбар байгууллагынхаа шилдгээр шалгарсан та бүхэндээ Засгийн газрын нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлж, үр дүнд хүргэхэд та бүхний оруулж буй хувь нэмэр, хичээл зүтгэл чухал байсан” гэдгийг онцлон ажлын амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг хүслээ.

## БНХАУ-ын 22 мянга гаруй иргэн Монголд хөдөлмөр эрхэлж байна

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат өчигдөр мэдээлэл хийлээ. Тэрбээр гадаадын ажиллагсад болон зарим халамжийн бодлогын талаар мэдээлэл хийв. Мэдээллийн эхэнд манай улсад ажиллах гадаад иргэдийн тоо 2013 онтой харьцуулахад дөрөв дахин буурсан талаар онцлоод цахим сайт, сонин хэвлэлд гарсан “Гаднын улс орноос олон мянган ажилчин оруулж ирж байна” гэсэн мэдээлэлд тайлбар өгөв. Монгол Улсад жилд 82 улсын иргэн хөдөлмөр эрхэлдэг байна. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар авч үзвэл, 2013 онд гаднаас нийт 27191 ажил, хөдөлмөр эрхлэхээр ирсэн гэнэ. Тухайлбал, БНХАУ-ын 22600, БНСУ-ын 1623 иргэн ажиллахаар иржээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

# ХАЙРАН НЭР ХҮНД...

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Бүр өчигдөр гэхэд хохирогч гэгдээд буй бүсгүйн эгч Ч.Саранзаяа мэдээлэл хийж, эхнээс нь зарим баримтыг дэлгэлээ. УИХ-ын гишүүн Д.Гантулгын найз Анхбаяр гэдэг залуутай хамт “Гурван гал” эмнэлэгт очиж ярьж байгаа бичлэгийг ил болгов. Түүнээс гадна хохирогч гээд байгаа бүсгүйн талаар ч харлуулсан мэдээлэл сошиалд тарсан. Энэ мэтээр хоёр талаас тэмцэлдэж байна. Цагдаа, хуулийнхан нь Д.Гантулга гишүүнийг буруугүй гэсэн шийдвэр гаргачихсан. Гэхдээ хохирогч тал бол хуулийнхан гишүүнд үйлчилж байна, эд мөрийн баримтыг устгасан. Цаашид ч олон баримт гаргаж тавина гээд байдаг. Одоогоор тэрний зөв, энэ нь буруу гэж хэлэх арга алга. Хамгийн гол нь энэ дунд УИХ-ын гишүүн гэдэг нэр төр сөвтэй байна. Төрийн нэр төр шороотой хутгалдчихлаа. Олон хүн УИХ-ын гишүүн Д.Гантулгыг хэрэг хийчихсэн нь үнэн юм биш үү гэдэг талаас нь харж байгаа.

...Энд Д.Гантулга гэдэг хүндээ ч байгаа юм биш. Гол нь УИХ-ын гишүүн ийм хэрэгт орооцолдсон гэдэгтээ л байгаа юм. Төрийн босго өндөр. Тиймээс л ийм асуудалд ямар нэг байдлаар, үнэн ч бай, худлаа ч бай холбогдоод баймааргүй. Холбогдох сэдэл, сэжим ч гаргаад байх хэрэггүй шүү дээ...

Хэнтий аймгийнхан хүртэл тайван жагсаал хийлээ. Угтаа бол УИХ-ын гишүүн гэдэг ард түмний төлөөлөл болж, хэрэгтэй хууль баталж ажиллах ёстой. Монголчууд төрөө дээдэлж, цайныхаа дээжийг хүртэл “Төрийн сүлд өршөө” гэж өргөдөг. Төр гэдэг өөрөө энэ хэдэн гишүүн, өндөр дээд албан тушаалтнууд биз дээ. Гэтэл нэг гишүүн элдэв хэрэгт орооцолдож, төрийн нэрийг шавартай хутгаж болох уу. УИХ-ын гишүүн юун улаан махны хэрэгт нэр холбогдож, үнэн, худал гэж хэлэлцэж, хэрэлдэж суух. Олон мянган иргэний төлөөлөл болохын хувьд чуулганы хурлаа ч таслах учиргүй биз дээ. Тийм болохоор энэ мэт хэргийг нэг тийш нь болгож, төрийн нэр хүндийг шавар шавхайнаас салгамаар байна. Хэрвээ Д.Гантулга гэдэг гишүүн үнэхээр хэрэг төвөгт холбогдчихсон юм бол

МАН-ынхан энэ хүнтэйгээ хариуцлага тооцоод, эргүүлэн татаад, шалгуулаач ээ. Үнэн мөннийг нь тогтоогооч. Сонгууль яах вэ, маргааш л дууслаа. Харин энэ асуудал дуусахгүй шинжтэй. Тийм болохоор ядаж намынхаа нэр хүндийг бодсон ч шийдэх хэрэгтэй биз дээ. УИХ-ын гишүүнийг зүгээр нэг хүн хийгээд, тэгээд тэр том нэр хүндийг шороотой хутгаад яваач байж болохгүй. Яахав, МАН Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэр дэвшигчийнх нь нэр хүнд унана гэж эмээгээд байгаа байх. Тийм болохоор

сонгуулийн дараа асуудлаа харууцлага тооцоод, эргүүлэн татаад, шалгуулаач ээ. Үнэхээр Д.Гантулга гишүүн хэрэг хийгээгүй бол яах вэ. Сонгуультай холбоотойгоор хамгийн залуу, юу ч хийж магадгүй гэдгээр нь түүний нэрийг ашиглаж байж ч болох. Асуудал хоёр талтай шүү дээ. Хэрвээ тийм бол одоо өөрөө гарч ирээд, мэдэгдэл хийгээд, батлаад, нэр төрөө цэвэрлэж аваач ээ. Ганц сайтад жаахан яриа өгөөд, өөр зүйл хийхгүй болохоор эргэлзэх хүмүүс олон болчихоод байна. Тийм

болохоор зургадугаар сарын 11-ний шөнө айлд хоноогүй, 12-ны өглөө тийм хэрэг хийгээгүй гэдгээ батлаад, мэдэгдэл хийгээд, нэрээ цэвэрлэж авах хэрэгтэй. Энд Д.Гантулга гэдэг хүндээ ч байгаа юм биш. Гол нь УИХ-ын гишүүн ийм хэрэгт орооцолдсон гэдэгтээ л байгаа юм. Төрийн босго өндөр. Тиймээс л ийм асуудалд ямар нэг байдлаар, үнэн ч бай, худлаа ч бай холбогдоод баймааргүй. Холбогдох сэдэл, сэжим ч гаргаад байх хэрэггүй шүү дээ. Гадаад орнуудад, тэр

дундаа Японд улстөрчид нь нэг үг хэлснийхээ төлөө албан тушаалаасаа огцорч байна. Биеэ үнэлэгч авсныхаа төлөө бүрэн эрхээсээ татгалзаж, огцорч байгаа улстөрчид ч олон байдаг. Тийм жишээ их. Гэтэл манайд болохоор зөв, буруугаа батлах ч үгүй хэрэлдсээр. Ийм зүйл байж таарахгүй ээ. Буруутай бол буруугаа хүлээгээд, ёс зүйтэйхэн шиг огцор. Буруугүй бол түүнийгээ батлаад, энэ асуудлыг нэг тийш нь болгох хэрэгтэй байна аа. УИХ-ын гишүүдийн нэр хүнд ингэтлээ унах ёсгүй.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

## Дахин санал хураалтдаа идэвхтэй оролцоорой

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Гэхдээ нэр төртэй хүмүүс ингэж хууль бусаар сонгуулийн сурталчилгаанд өөрийнх нь зургийг ашигласныг зүгээр өнгөрөөхгүй байх. Нөгөө талдаа цагаан сонголт гэж уриалаад байгаа хүмүүсийн үгэнд автаж, ард түмэн ялна гэсэн хоосон урианд нь итгэхгүй байхыг залуучууд, иргэдээс хүсмээр байна. Дахин санал хураалттайгаа нийлээд Засгийн газар 20 гаруй тэрбум үрж байгаа. Цэцэрлэг, сургууль барих, бүтээн байгуулалт хийх болохоор мөнгөгүй гээд татагнаад байдаг Монгол Улсын Засгийн газар сонгуульд бол зүгээр л цацдаг юм байна. Ядаж байхад эх орондоо хайртай гэж худлаа сүржигнэдэг, аль хэдийн өвдөг шороодсон зарим нэг хүн “Цагаан сонголт” гэж уриалаад сууж байгаа нь ямар их худал хуурмаг вэ гэж дуу алдахаар болчихож. Цагаан сонголт гэж уриалаад байгаа хүмүүс ялаад, тунаж үлдсэн хоёр нэр дэвшигчийн хэн нь ч 50 хувиас дээш санал авахгүй байа гэж бодь. Тэгвэл дахиад өөр гурван хүн гарч ирж, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөнө. Дахиад 14, 15 тэрбум төгрөг үрнэ. Хэн нэг нь олонхийн санал авахгүй бол нэмэлт санал хураалт явна. Ингээд л үргэлжлээд байх уу. Эсвэл хэн нэг нь найдвартай ялна гээд найдаж суух уу. Ийм дүүрчихсэн тэнэг юм гэж байж болохгүй ээ. Тэгж байхээр залуус минь бүгдээрээ идэвхтэй саналаа өгцгөөе. Бүр тэгэхээс тэгэх гэж 100 хувь саналаа өгцгөөе. Игтэл үнэмшлээ дагаж, хэн нэгнийг нь дэмжиж гаргая. Нэгдүгээрт, улсын энэ их мөнгө төгрөг хий дэмий урсахаас сэргийлэх хэрэгтэй. Хоёрдугаарт, цагаан сонголт нэрийн цаана нуугдаж байгаа алив хар муу бүхнээс сэргийлэх цаг болсон. Тэртээ тэргүй ирэх ням гараг ажлын өдөр болчихсон. Тиймээс түүнээс өмнө хөдөө гадаа явна гэж байхгүй. Даваа гарагаас л наадам наргиан, амралт зугаалга эхлэх байх. Тиймээс баасан гарагт нийтээрээ, дорвитойхон саналаа өгчих хэрэгтэй юм. Сонгуульдаа идэвхтэй оролцооор байна аа, залуус аа. Сошиалд хий бухимдаж, ухаантай ухаантай юм бичиж, эсвэл хэн нэгнийг сохроор дагаж, хар пиарт автаж сууснаас дөрвөн жилдээ ганц, хоёрхон удаа олддог төрийн эрх барихад нөлөөлөх эрхээ эдлэх хэрэгтэй шүү дээ. Миний саналаар дутав л гэж, санал өгөхгүй байлаа гээд яадаг юм гэж бодож яваа бол буруу. Таны саналаар дутдаг юм. Хэн нь ч гэсэн. Санал өгөхгүй бол ирц, дүн хүрэхгүй, дахин санал хураалт болж байгаа биз. Тэгээд ард түмэн бидний хуруу хумсаа хуйхдаж хэдэн төгрөгөөс авсан татварын мөнгөөр дахиад л сонгууль дана. Энэ янзаараа хэн хэнийгээ бойкотлоод яваад байвал хэчнээн ч удаан сонгуульдаж магадгүй. Заавал нэг Ерөнхийлөгчтэй болж байж л сална. Тиймээс л саналаа өгчих хэрэгтэй. Уг нь эхний сонгуулиар залуурч хэвтсэн 600 мянган сонгогч саналаа өгчихсон бол бид дахиад 7.2 тэрбум төгрөг үрэхгүй, дахин санал хураалт гэж заваарахгүй л сууж байх байлаа. Гэвч үүргээ мэддэггүй, хий эрх чөлөө ярьсан, хамраасаа цаадахыг харж чаддаггүй олон хүнээс болоод нийт монголчууд хохироод л сууж байна шүү дээ. Тиймээс та идэвхтэй бол, тэгээд хажууд чинь унтахаас өөр шидгүй, юугаа ч ойлгохгүй, миний саналаар дутахгүй гэсэн хүн болдолтой нөхөр байгаа бол чирж гараад, саналыг нь өгүүллээрэй. Дахиад бидэнд 10, 20 тэрбумээр сонгуульдах чадал байхгүй.

### САЙН МЭДЭЭ

## 2017 онд махны экспортын орлого 100 тэрбумд хүрнэ гэв

### Б.ТОГТОХ

Засгийн газар, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас “Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн” зорилтын хүрээнд мах, сүүний анхдугаар аяныг өрнүүлж байгаа билээ. Энэ аяны хүрээнд махны экспортыг дэмжиж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хонь, ямааны махыг зорилтот зах зээлд нийлүүлэх, тогтвортой урт хугацаанд экспортод гаргах бодит алхамыг хийж байгаа юм. Тодруулбал, өнгөрсөн долоо хоногт Монгол Улсаас Иран улс руу “Eco food trading” ххк, “Darkhan meat foods” ххк хамтран 4000 тонн хонины мах экспортлох гэрээ байгуулан эхний ачилгаа хийсэн. Харин өнгөрөгч мягмар гарагт “Мах маркет” ХХК БНХАУ руу 1200 тонн боловсруулсан мах махан бүтээгдэхүүн, Исламын бүгд найрамдах Иран улс руу 2000 тонн, Бүгд найрамдах социалист Вьетнам улс руу 200 тонн хонь, ямааны махыг экспортлож байна. Энэ жил Иран улсад нэг тонн хонины махыг 3000 ам.доллараар тооцож 6000 тонн мах нийлүүлэхэд 18 сая ам.доллар, Вьетнам улсад 200 тонн ямааны махыг 740 мян.ам.доллар буюу 1 кг махыг 3.7 ам.доллараар, БНХАУ-д дулааны аргаар



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг дунджаар 1 кг-ыг нь 5 ам.доллараар тооцоход нийт 1200 тонн махан бүтээгдэхүүнийг 6 сая ам.доллараар тус тус экспортлох юм. Эдгээр 5 улс оронд 2017 оны 5 дугаар сарын байдлаар нийт 5283 тонн мах, махан бүтээгдэхүүнийг 10 сая ам.доллараар экспортлож, одоогийн байдлаар 23.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2017 оны хоёрдугаар хагаст буюу мал бэлтгэлийн үеэр махны экспортын хэмжээг мах боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжийн гадаад улс оронтой байгуулсан гэрээний дагуу урьдчилан тооцоход дунджаар 30 сая ам.доллар болж байна. Дээрх тооцоог үндэслэн 2017 онд махны экспортыг урьдчилан тооцоход нийт 15 000 тонн мах, махан бүтээгдэхүүнийг дунджаар 40

сая ам.доллараар экспортлож, махны экспортын орлого 100 орчим тэрбум төгрөгт хүрэх тооцоо байна. Өсч үрждэг малынхаа махыг экспортод гаргаснаар малчдын орлого нэмэгдэж, үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай тогтворжиж, тогтмол ажлын байр нэмэгдэж, Хөдөө аж ахуй салбар улсын эдийн засагт бодит хувь нэмэр оруулах юм. Энэ талаар ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн

“Мах сүүний анхдугаар аян”-ы хүрээнд олон ажил хийхээр төлөвлөсний нэг нь махны экспортыг нэмэгдүүлэх. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд хонь, ямааны махыг зорилтот зах зээлд гаргах буюу гуравдагч орнуудад махны экспортын зах зээлийг нээхэд онцгой анхаарч ажиллалаа. Махны экспорт 2017 оны эхний хагас жилийн байдлаар хоёр дахин нэмэгдсэн байна. Манай улс Исламын Бүгд Найрамдах Иран, Вьетнам, БНХАУ, ОХУ, Казакстан, Катар зэрэг улсуудад мах болон махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаа амжилттай эхлээд явж байна. Одоо бидэнд экспортынхоо үйл ажиллагааг тогтвортой, найдвартай урт хугацаанд үргэлжүүлэхийн тулд олон зүйлийг хийж хэрэгжүүлэх ёстой. 2017 онд зорилтот зах зээлд мах экспортлох ажлыг эхлүүлсэн мах боловсруулах үйлдвэрүүдийн экспортын нийт орлого 25 сая ам.доллар буюу 60 орчим тэрбум төгрөг болж байгаа юм. 2017 онд махны экспортыг урьдчилан тооцоход нийт 15 000 тонн мах, махан бүтээгдэхүүнийг дунджаар 40 сая ам.доллараар экспортлож, махны экспортын орлого 100 орчим тэрбум төгрөгт хүрэх юм. Энэ бол үр дүн” гэдгийг онцлов.

## УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЦАХИЛГААНЫ ШӨНИЙН ТАРИФЫГ НИЙСЛЭЛД 100,  
ОРОН НУТАГТ 50 ХУВЬ ХӨНГӨЛНӨ

Б.ДАВААХҮҮ

Өнгөрсөн өвөл нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нүдээ олсон арга хэмжээний нэг нь гэр хорооллын иргэдийн цахилгааны хэрэглээний шөнийн тарифыг тэглэх шийдвэр байсан билээ. Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд Засгийн газраас өнгөрөгч оны арванхоёрдугаар сард нийслэлийн гэр хорооллын хоёр тарифт тоолууртай айл өрхийн шөнийн тарифыг тэглэх тогтоол гаргасан. Энэ дагуу энэ оны нэгдүгээр сараас гуравдугаар сарын 31-ний өдрийг дуустал нийслэлийн гэр хорооллын өрхийн 21:00-06:00 цаг хүртэл хэрэглэсэн цахилгааныхаа тарифыг тэглэсэн байдаг. Ингэснээр айл өрхүүд цахилгаан халаагуур хэрэглэн цэвэр орчинд амьдрах нөхцөл боломж бүрдсэн. Иргэд ч түүхий нүүрс, зуухнаас татгалзаж, төрөл бүрийн халаагуур сонгон хэрэглэх болсноор утаат яндангийн тоо тодорхой хэмжээнд буурсан юм.

Тэгвэл ирэх өвөл ч уг арга хэмжээ үргэлжлэх нь. Гэхдээ илүү өргөн цар хүрээтэй, илүү урт хугацаанд үргэлжлэхээр болсон байна.

Тодруулбал, Засгийн газрын мягмар гарагийн хуралдаанаар агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд “Гэр хорооллын айл өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх” журмыг хэлэлцэж, шинэчлэн баталжээ. Энэ журмын дагуу халаалтын улиралт нийслэлийн гэр хорооллын өрхийн орой, шөнийн



цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100, аймгийн төв болон 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааны хэрэглээний тарифыг 50 хувь хөнгөлөхөөр болсон байна. Өмнө нь буюу өнгөрөгч өвөл зөвхөн нийслэл болон төвийн бүсийн гэр хорооллын айл өрхүүд цахилгааны хөнгөлөлт хамрагддаг байсан бол Засгийн газрын шинэчлсэн журам хэрэгжиж эхэлснээр Улаанбаатар хот төдийгүй, 21 аймгийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал, Ховд аймгийн Булган сум, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд, Налайх, Багануур зэрэг 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газрууд хамрагдах боломжтой болсон байна. Энэ талаар Эрчим хүчний сайд П.Ганхүү “Хамгийн гол нь

оргил ачааллын үетэйгээгээ давхицуулахгүйгээр шөнийн тарифыг хөнгөлөх асуудлыг шийдсэн. Нөөц боломж бага гэж ярих бус, нийслэл хотын гэр хорооллын айл өрхөө халуун дулаан өвөлжихөд нь дэм үзүүлэх ёстой. Өмнө нь гурван сарын хугацаагаар шөнийн тарифыг хөнгөлж байсан бол энэ жилийн тухайд таван сар болгон сунгасан. Тэгэхээр ирэх арваннэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ” гэлээ.

Ямартай ч, цахилгааны шөнийн тарифыг нийслэлд 100, хөдөө орон нутагт 50 хувь хөнгөлөх нь. Харин цаашид хэрэглэгчид, эрчим хүчний салбарынхны аль аль нь өвлийн бэлтгэлээ сайтар хангаснаар бодит үр дүнгээ өгөх боломжтойг салбарын сайд онцолж байсан юм.

Эрчим хүчний салбарынхны тухайд эдүгээ шугам сүлжээний

шинэчлэлтийн зураг төслөө гаргаж, тодорхой ажлуудыг шат дараатайгаар төлөвлөн хийж эхэлжээ. Харин хэрэглэгчид буюу хөнгөлөлт эдлэх боломжтой гэр хорооллын өрхүүд нэгэнт Засгийн газраас утааг бууруулах чиглэлд хүчин чармайлт гарган утааны улиралт эхлэхээс даруй дөрвөн сарын өмнө цахилгааны тарифыг хөнгөлөх шийдвэр гаргасантай холбоотойгоор үлдсэн хугацаанд хувийн бэлтгэлээ сайтар хангах хэрэгтэйг энд дахин санууля. Иргэн, өрх бүр агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж буй төр, засгийн шийдвэрийг дэмжин цахилгаан халаагуур худалдан авах, гэр рүүгээ орсон шугамын утсаа цэгцлэх, аюулгүй байдлаа хангах, гэр, сууцаа дулаалах зэргээр дор бүртгээ бэлтгэлээ хангаснаар нийслэл хотын

агаарын бохирдол төдий хэрээр буурах билээ.

Дашрамд дурьдахад, өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд гэр хорооллын 140 гаруй мянган айл өрх халаалтын улиралд шөнө хэрэглэсэн цахилгааны төлбөрөө 100-50 хувь хүртэл хөнгөлүүлэх урьдчилсан тооцоо гарчээ. Засгийн газраас шинээр баталсан журмын дагуу 2017-2018 оны хүйтний улирлын үргэлжлэх болон цахилгааны орой, шөнийн тарифыг мөрдөх

хугацаа, хөнгөлөлтөд хамрагдах хэрэглэгчийн цахилгааны хэрэглээний дээд хязгаарыг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний хүчин чадал, техникийн боломжоос хамааруулж Эрчим хүчний зохицуулах хороо тогтоосон байна. Цахилгааны шөнийн тарифыг хөнгөлөх тухай тус журам хэрэгжихэд 9.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр байгаа бөгөөд үүнийг Засгийн газар татаасаар шийдвэрлэхээр болсон байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн  
нэгдсэн  
үйлчилгээний  
төвөөр наадмын  
тасалбар  
худалдана

Үндэсний их баяр наадмын тасалбарыг энэ сарын 8, 9-ний өдрүүдэд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дунжингарав, Драгон, Мишээл, Оргил салбаруудаар худалдаалах гэж байна. Өнгөрсөн жилүүдэд Соёлын төв өргөө, Бөхийн өргөөний тасалбарын цэгээр худалдаалагдаж байсан ч иргэдээс маш их гомдол ирдэг байсан юм. Иймээс энэ жил иргэдэд бухимдалчирэгдэл, уртдараалал үүсгэхгүйн тулд ийм шийдвэр гаргажээ. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү “Өмнө нь хоёр цэгт тасалбар борлуулахад иргэд хонож дугаарлан, бухимдал маш их үүсдэг байсан. Энэ жил Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 4 салбараар худалдаалснаар иргэд өөрийн амьдарч байгаа дүүргийнхээ нутаг дэвсгэрт ойролцоо цэгээс авах боломж бүрдэнэ. Иргэдэд илүү хүртээмжтэй байна гэж бид үзэж байна. Мөн тасалбарыг дамалж худалдаалах байдал намжина гэж тооцоолсон. Цэнгэлдэх хүрээлэнгийн суудлын тоо бага. Нийслэлийн иргэд олон учраас бид иргэдэд аль болох хүртээмжтэй байхыг нь бодож өмнөх жилүүдийн адил 1 хүнд 2 тасалбар худалдаална” гэлээ. Төв цэнгэлдэх хүрээлэн нийт 12 мянга 300 орчим суудалтай. Нийт борлуулах тасалбараас 3000 гаруй нь жуулчдад зориулсан бол үлдсэн 9000 гаруй тасалбарыг иргэдэд борлуулах юм байна. Баяр наадмын тасалбарын үнийн хувьд долдугаар сарын 11, 12-ны өдрийн багц тасалбар 16-24 мянган төгрөгийн үнэтэй байх юм.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ”  
ТӨХК төрийн дээд одон хүртлээ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигаар түүхт 50 жилийн ойгоо угтаж буй Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийг төрийн дээд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагналаа.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК тэртээ 1967 онд буурна засч, өрхөө татаж байсан бол эдүгээ аль хэдийнэ 1000 гаруй ам бүлтэй, эрчим хүчний салбарын түлхүүрийг атгах томоохон өрх айл болтлоо өргөжин хөгжиж иржээ. Тус компанийн ойн баярын хурал өчигдөр Корпорейт конвеншн центрт зохион байгуулагдсан юм. Энэ үеэр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн



тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Д.Чинбат “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК үүсгэн байгуулагдсаны 50 жилийн ой тохиож байна. Одоогоос 50 жилийн

тэртээ 1967 онд Улаанбаатар, Дархан хотыг цахилгаан эрчим хүчээр хангах 110 кВ-ын анхны шугам тавигдсанаас хойш манай компанийн суурь тавигдсан гэж үздэг. Харин өнөөдөр тэр

үетэй харьцуулахад 1000 гаруй ажиллагсадтай Монгол Улсын 70 гаруй хувийг цахилгаан, эрчим хүчээр хангадаг үндэсний хэмжээний томоохон компани болж хөгжсөн байна. Манайх эрчим хүчийг үйлдвэрлэгчээс түгээгчид дамжуулдаг нэг ёсны тээврийн компани юм” хэмээгээд нийт ажилчиддаа баярын мэнд хүргэлээ. Улмаар энэ үеэр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан Ерөнхийлөгчийн зарлигийг уншиж танилцуулан, 16 аймаг 300 гаруй сумын иргэдийг цахилгаан эрчим хүчээр хангаж, Монгол Улсыг хөгжүүлэх үйлсэд мэргэжил ур чадвараа зориулан хичээн хөдөлмөрлөж ирсэн тус байгууллагын үе

үеийн ажилтан албан хаагчдын хичээл зүтгэлийг төр өндөрөөр үнэлж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж буйг уламжлан, гардуулан өгсөн юм. Түүнчлэн, Эрчим хүчний сайд П.Ганбат эх орныхоо гал голомтыг мөнхөд бадрах эрчим хүчийг найдвартай дамжуулах компани юм” хэмээгээд биелүүлж, эрдэм мэдлэгээ зориулж яваа салбарын нийт хөдөлмөрчиддөө Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа баяр хүргэлээ. Дашрамд сонирхуулахад, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК Улаанбаатараас Дорноговь чиглэлд Монголдоо хамгийн томд тооцогдох 330 кВ-ын өндөр хүчдэлийн шугам тавихаар төлөвлөж, шавыг нь тавьсан байна.

## Хүүхдийн мөнгийг бүх хүүхэд олгож эхэллээ



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүүхдийн мөнгийг бүх хүүхэд сар бүр олгох зорилтыг тусгасан. Уг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын 2017 оны төсөвт 660 мянган хүүхдэд хүүхдийн мөнгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгохоор 161.5 тэрбум төгрөгийг тусгаад байгаа юм. Эхний ээлжинд хүүхдийн мөнгийг амьжиргаа багатай зорилтот өрхийн 660 мянган хүүхдэд сар бүр 2017 оны зургадугаар сарыг дуустал олгоод байна.

Харин эдийн засгийн өсөлтийн үр дүнд 2017 оны төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэн төсвийн зорилтот үзүүлэлтүүд сайжрах төлөвтэй байгааг харгалзан Монгол

Улсын Засгийн газрын 2017 оны долдугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт өрхийн хүүхэд бүрт мөнгийг нь олгохоор шийдвэрлэлээ. Үүний дагуу өчигдөрөөс /2017.07.05/ эхлэн хүүхдийн мөнгөө аваагүй байсан 400 мянга орчим хүүхдийн мөнгийг нөхөж олгож эхэллээ. Өөрөөр хэлбэл, мөнгөн тэтгэмжээ аваагүй байсан хүүхэд бүрийн 140 мянган төгрөгийг өмнө нь авч байсан арилжааны банкны дансаар нь дамжуулан шилжүүллээ. Ингэснээр бүх хүүхэд мөнгөө авах боломж бүрдлээ.

Өнгөрсөн хугацаанд шинээр төрсөн хүүхдийнхээ мөнгийг авахын тулд эцэг, эх нь өөрт ойрхон арилжааны банкинд очиж өргөдлийн маягыг бөглөн, данс нээлгүүлж хүүхдийн мөнгөө авах боломжтой юм.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

Манай сонины III улирлын нэмэлт захиалга явагдаж байна

Улиралд **44** дугаар

**Захиалгын үнэ 19800**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

# ОНЦЛОХ ХУУДАС

## Өүг үү өүг аү?

# “Яах вэ дээ” АНГИЛЛЫН ТҮШЭЭ



### Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

УИХ-ын гишүүн Х.Болорчулуун улс төр хийгээд бизнест одтой эр. Ингэж хэлэх хүнтэй олон тааралдсан. Туулсан замналыг нь харахад ч мөн л тийм сэтгэгдэл төрөхөөр юм билээ. Үнэндээ тэр УИХ дахь чадвартай гишүүдийн тоонд багтдаггүй. Дорнод түмнийг төлөөлж, төрийн сааралордонд зургаа дахь жилдээ заларч байгаа ч Х.Болорчулуун авторлогдох хуулийн төсөл одоо хэр нь төрөөгүй л байгаа. Уг нь тэрбээр огт хууль санаачлаагүй юм биш. Өмнөх парламентад тодруулбал, 2015 онд “Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Халхгол” хөдөө аж ахуйн бүс байгуулах тухай” тогтоолын төслийг УИХ-ын даргад өргөн барьсан удаатай. Мөн Газрын тосны тухай хуулийн төслийг ахалж ажилласан. Харамсалтай нь УИХ дээр уначихсан. Гэх мэт ганц нэг тогтоолын төсөл дээр ажилласан санагдана. Шулуухан хэлэхэд, яг өөрөө санаачилж, боловсруулаад УИХ-аар батлуулсан хуулийн төсөл байхгүй. Яах вэ, хаа нэгтэй байр сууриа илэрхийлж байгаа харгаддаг. Үг хэлэхдээ ч тааруухан шүү дээ мань хүн. Гэхдээ арай ч “хэлгүй”-чүүдийн эгнээ рүү орчихгүй л дээ. Гэвч үнэн мөнийг хэлж, үзэл бодлоо илэрхийлэх талаар “яах вэ дээ” ангиллын хүн. Ерөнхийдөө өнгөрсөн УИХ-ыг хууль боловсруулах ажилтай танилцах л маягаар үдсэн гэж дүгнэж болно. Дээр нь чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороодын хурлыг үе үе

таслахыг нь яана. Ийм нэг түшээ Дорнод түмнийг УИХ-д төлөөлдөг. Тодруулбал УИХ-ын 15 дугаар тойрогт.

### Үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс өөрөө баяжсан гишүүн

Хэвлэл мэдээллийн цөөнгүй хэрэгслээр нэг хэсэг ийн цоллуулаад авсан. Тодруулга, тайлбарыг хийхэд, Засгийн газар, Монголбанкнаас хамтран хэрэгжүүлсэн Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зорилгын хүрээнд гурилын үйлдвэрүүдэд шинэ ургацын хүнсний буудай худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл олгох замаар гурилын жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулахыг хичээсэн билээ. Энэхүү хөтөлбөрт УИХ-ын гишүүн Х.Болорчулуун өөрийн “Дорнод гурил” компаниа багтаасан гэх яриа байдаг. Хэрэв энэ үнэн бол мань эр аль нэг арилжааны банкаас зээл авсан байж таарах гээд байгаа юм. Тэгсэн атлаа УИХ-ын чуулганаар Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг ярилцах үеэр Монголбанкны тухайн үеийн удирдлагыг буруутган байрсууриалерхийлж байлаа. Эл үйлдэл нь түүнийг нийгэмд байр суурыгуй харагдуулсан болов уу. Ямартай ч тэрбээр УИХ-ын 2016 оны сонгуулийн үеэр гурил тараасан гэнэ лээ. Хөтөлбөр хэрэгжиж, хөнгөлттэй зээлд хамрагдсаны үр ашгийг ингэж тэр эдэлсэн. Ер нь тэр одтой л доо. Мань хүний бизнес УИХ-ын гишүүн болсноос нь хойш илт сэргэсэн аж. “УИХ-

ын гишүүн Х.Болорчулуун барилга онцгой объектийн бүсэд сүндэрлэж байна” гэх мэдээлэл хүртэл гарч байлаа. Гурилын бизнес нь өргөжөөд Улаанбаатар хотод барилга барьсан явдлыг нь хэлсэн хэрэг. Энэ талаархи мэдээллийг цахим хуудсаас уншиж болно. Тэгэхээр УИХ-ын гишүүн болсноор бизнесээ өргөжүүлэхээс өөр юм хийсэнгүй юу гэсэн асуулт гарч ирж байна.

### Ноёд урваач...

УИХ-ын гишүүн Х.Болорчулуун улс төрд шинэ хүн биш. Бас ирээдүйтэй нэгэн ч биш. Шулуухан хэлэхэд, улстөрчийнх нь карьер 2020 оноор өндөрлөх нь дамжиггүй. Дорнодчууд мань эрийн улс төрийн угшлыг нь “Иргэний Зориг” нам гэж тодорхойлсон. Тэрбээр хамгийн анх Иргэний зориг намд элсч байжээ. Тэгээд намынх нь нэр нөлөө буурч эхэлмэц МАН-тай хөтлөцөн хэсэг гүйсэн байдаг. Мэдээж түүнд орон зай оллоогүй. Харин өөрөө энэ тухайгаа, “Хүн эхлээд өөр өөрийгөө л болгохыг хичээдэг юм билээ. Өөртөө болоод ирэхээрээ ах дүү, найз нөхдөө бодож эхэлнэ. Дараа нь нутаг орноо, Монгол Улсаа бодож эхэлдэг юм байна. Оюутолгойн гэрээг Монголын ард түмэнд ашиггүй байгуулсан нь иргэн хүний хувьд бухимдлыг минь ихээр төрүүлсэн. Магадгүй энэ нь намайг улс төрд хөл тавих гол хөшүүрэг болсон болов уу” хэмээн маш цэвэрхэнээр тайлбарлажээ. Мөн бие даах болсон талаараа “Надад

олон нам манайд орооч гэсэн санал тавьдаг байлаа. Гэсэн ч бие дааж нэр дэвшихийг илүүд үздэг. МАН-д орсон нь миний хувьд алдаа байсан. Би энэ намыг нэрээ сольж, шинэчлэгдтээ гэхэд нь итгээд орчихсон юм. Бодит байдал дээр энэ нь худлаа байсан. Тиймээс би жил хүрэлгүй МАН-аас гарсан. Энэ намын гишүүнчлэлээс татгалзаад намын батлахаасаа зургаа хуулж авахад цаана нь цэвэрхэн цааслүдсэн юм шүү” гэжээ. Ийм л улс төрийн байр суурьтай нөхөр их улс төрд хөл тавьсан түүхтэй. Тэрбээр Дорнод аймгийн ИТХ-д гурван удаа төлөөлөгчөөр суусан төдийгүй УИХ-ын 2012 оны сонгуульд бие даан нэр дэвшиж ялалт байгуулсан. Харин 2016 онд муулж байсан намдаа эргэн элсч ялалтад хүрчээ. Дорнодчууд түүнийг муу хэлэн өөлөх атлаа итгэл хүээлгэн төр түшүүлэхээр илгээдэг нь өнөө хэр сонирхолтой сэдэв хэвээр.

### Агрономич түшээ

Х.Болорчулуун арван хүүхэдтэй айлын том нь. Бас дүү нартаа эцгийнхээ оронд эцэг болж яваа нэгэн. Магадгүй түүний багадаа туулсан хатуу амьдрал алив асуудалд бие даан шийдвэр гаргахыг илүү үздэг болгосон байж ч мэднэ. Тэрбээр 1982 онд Дорнод аймгийн 10 жилийн дунд сургууль, 1987 онд Хөдөө аж ахуйн дээд сургуулийн агрономичийн ангийг тус тус дүүргэсэн. Төрд ажилласан туршлагын тухайд Дорнод аймгийн Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд

мэргэжилтэн, Булган суманд агрономичоор ажилласан төдий. Харин 1992 онд эзэмшсэн мэргэжлийнхээ хэргийг хийн “Хишиг аж ахуй” компаниа байгуулан төмс, хүнсний ногоо, үр тариа тариалах болсноор хувийн хэвшилд хөл тавьсан, хөл дээрээ ч боссон. Хожим 1997-онд олон нийтийн нээлттэй дуудлага худалдаанаар “Алтан тариа” компаниа ширүүн өрсөлдсөний дүнд “Дорнод гурил” компанийг өөрийн болгож чаджээ.

### Тэрбумтнуудын жагсаалтад багтсан Х.Болорчулуун

УИХ-ын гишүүн Х.Болорчулуун тэрбумтны тоонд багтахгүй ч хоосны тоонд орохгүй. АТ-т гаргаж өгсөн хөрөнгө оруулгын мэдүүлгээс нь харвал удахгүй тэрбумтнуудын жагсаалтад бичигдэж мэдэхээр юм билээ. Ямартай ч тэрбээр хувьдаа дөрвөн орон сууцтай. Зөвхөн өөрийнх нь жилийн орлого 66 сая. Тодруулбал, 66534.43 төгрөг бол эхнэрийнх нь 10593.34 төгрөг аж. Дансандаа 597416.46 төгрөгийн хадгаламжтай. Мөн 475000.00 өртөг бүхий үйлдвэр үйлчилгээний объекттэй юм байна. Унаа машины тухайд мань хүн 80 саяар үнэлэгдэх Mercedes Benz, G50-тай. Адуунд дургүй монгол хүн гэж үгүй билээ. Тэрбээр 120 гаруй тооны адуутай. “Хишиг Агро” ХХК, “Дорнод гурил” ХХК-ий хувьцааг зуун хувь эзэмшдэг гэхээр мань хүний хөрөнгө тэрбумаар хэмжигдэж байгаа юм.

Тал нутгийн цахим мэдээлэл

## ЦАГ ҮЕ

Би МОНГОЛОО  
ИНГЭЖ ХӨГЖҮҮЛНЭ

Төгсгөл.  
Түрүүч нь I нүүрт

“Хүүхдүүд бол сүү, жүсийг нь уудаг болохоор “Монфрэш”-ийг андахгүй. Зарим нь бүхэл бүтэн жилийн турш савыг нь цуглуулж хөөрхөн хөөрхөн бүтээл урлаж, уралдаанд оролцдог юм билээ. Гэхдээ мэдэхгүй зүйл бас зөндөө. Тухайлбал, танай компани ямар хөрөнгө оруулалтаар яаж хөл дээрээ боссон юм бол гээд асууж сонирхох зүйл олон?”

“Монфрэш сүү” компанийн маань тулгын чулуу 1998 онд тавигдсан. Түүнээс хойш 20 жилийн ойттойгоо золгох гэж байна. Бидний бас нэг онцлог бол бусад үйлдвэрүүд шиг социализмын үеийн хөрөнгийг хувьчилж аваагүй. Өөрийн хөрөнгөөр, нүцгэн гараараа бүхнийг бий болгож босгосон үндэсний цор ганц үйлдвэр гэдгээрээ бахархдаг. Манай компанийн хувьд өнөөдөр ч бүх зүйлийг дотоод нөөц бололцоогоороо хийж байгаа. Ямар нэгэн гадаад эх үүсвэр тухайлбал, Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэргээс нэг ч төгрөг, нэг ч центийн зээл тусламж авч байгаагүй амжилттай яваа дотоодын цөөн компанийн нэг. Өр эзэлгүй, дотоодын эх үүсвэрээрээ явж байгаа цор ганц компани. Ер нь үндэсний үйлдвэрүүд гэж яригддаг ихэнх компани хуучны барилга ч байдаг юм уу, үйлдвэрийг хувьчилж аваад явж байгаа. Тэгээд тэр хувьчилж авсан объектоо магадгүй өр зээлдээ өгчихсөн

эмээ нар хуруугаараа долоож үзээд л авч байгаа харагддаг. Эрүүл ахуй талаасаа энэ нь хэр зохимжтой гэж та үздэг вэ?”

Хүнсний аюулгүй байдлаа бодож үзвэл гар дээрээ шингэн сүү худалдах нь тохиромжгүй. Энэхүү журам ер нь хэрэгжихгүй байгаа. Тийм учраас л өнөөдөр вагоноор сүү зөөж, арину цэврийн горим алдагдсан бүтээгдэхүүнийг зарим иргэн хэрэглэж байна шүү дээ. Үүнийг бид тогтолцоогоор нь шийдэхгүй бол нэг дүрэм журам гаргаад л нэг газар нь мөрдөхгүй яваад байдаг. Үүнийг эсрэг бид инновацижуулсан үйл ажиллагаа явуулж нийт 70 хөргөлтийн төвийг Улаанбаатар хотыг тойруулан байгуулж, бэлэн болгочихсон байгаа. Ингэснээрээ манай компани “Өүлэн”, “Биеэ бодоорой”, “Шоколадтай сүү” гээд бүх төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнээ эрүүл ахуйн шаардлага, горимд нийцсэн шингэн сүүгээр үйлдвэрлэж байна.

Гэхдээ уучлаарай, манай иргэд, хэрэглэгчдийн дунд “Манай сүүний үйлдвэрүүд урд хөршөөс хуурай сүү импортлож, түүгээрээ шингэн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг юм билээ” гэдэг амнаас ам дамжуулсан ойлголт яваад байдаг шүү дээ. Тэгэхээр танай компани ямар үүлдрийн хэчнэн үнэтэй вэ. Өөрсдийн гэсэн малчин, саальчин байна уу. Аль эсвэл тэр, энэ гэхгүй малчдаас ирсэн сүүг зохих үнийг нь төлөөд авчихаж байна уу?

Манай компани малчидтайгаа харилцаж, тэдний гар дээрээс



Гэрэл зургийг Т.АРТ УУЖИН

## Ж.Тэмүүлэл:

# БИД ОЛОН ЗҮЙЛЭЭР АНХДАГЧ БОЛСОН ҮНДЭСНИЙ КОМПАНИ

байдаг. Зарим нь өнөөг хүртэл хувьцааг нь эзэмшээд явж л байна. Харин “Монфрэш сүү” компанийн хувьд 100 хувь дотоодын хөрөнгө оруулалттай. Анх бид “Таван эрдэнэ” компанийн хашаанд жижигхэн талбай түрээслээд л ажлаа эхлүүлж байлаа. Цэвэр өөрсдийн хичээл зүтгэлээр босгож ирсэн компани даа.

Монголд анх удаа тетрапак савалгааг нэвтрүүлж байсныг чинь мэднэ. Үүнээс гадна ямар технологийн хувьсгалыг нэвтрүүлж, эх орныхоо хөрсөнд нутагшуулж байж энэ амжилтыг бүтээв?

Манай компанийн хувьд Монголд анх удаа буюу 1998 онд тетрапак савалгааг нэвтрүүлсэн. Анхны бүтээгдэхүүн маань, одоо ч зах зээлд байгаа 250 мл-ийн “Монфрэш шүүс”. Дараа нь нэг литрийн савалгаагаар болгож бүтээгдэхүүнээ гаргасан. Тэгээд тетрапак технологио ашиглан сүүний зах зээлд хөл тавьсан юм. Манай компанийн хийж бүтээсэн томоохон ажлын нэг нь 2011 оноос эхлээд сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцоог өөрийн хөрөнгөөрөө буюу ямар ч зээл тусламжгүйгээр эргүүлж сэргээсэн. Өмнө нь социализмын үед улсын үйлдвэр болох “Сүү” компанийн сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцоо байсан ч зах зээлийн шуургуанаар нуран унасан байлаа. Гэхдээ бид энэ тогтолцоог эргэж сэргээхдээ инновацийг ашигласанаараа онцлогтой. Хөргөлтийн төв гэхэд өмнө нь зүгээр л хүйтэн усаар хөргөдөг байсан бол одоо арину цэвэр шинэ төвшинд гарч, бүх зүйл нь автоматжсан жижиг үйлдвэр маягтай болж өргөжсөн байгаа. Ер нь хүний гар оролцохгүйгээр анхан шатны дамжлага буюу сүүгээ шүүх, цэвэрлэхээс эхлээд бүх зүйл автоматжсан. Үүгээрээ давуу талтай юм.

Өндөр технологи нэвтрэж, үйлдвэр хөгжихийн хэрээр иргэдийн соёл, ухамсар ч арай ондоо болох ёстой болов уу. Гэтэл улсын нийслэл рүү задгай сүү оруулахгүй гэдэг журам уг нь байдаг. Гэвч олон айлын эзэгнэй өнөөдөр “Сүүгээ аваарай” гэж хашгирах дуунаар сэрдэг нь нууц биш. Бүр зарим томоохон дэлгүүр, хар захын лангуун дээр ч задгай сүүг зарж л байдаг. Ээж,

...Сүүн төрлийн 20 орчим бүтээгдэхүүн, шүүсэн төрлийн 30 орчим бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийтдээ 50 орчим төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж байгаа. Сүү нийлүүлэх тогтолцоог бий болгосноор манай компани бүх бүтээгдэхүүнээ шингэн сүүгээр үйлдвэрлээд зогсохгүй анхны экспортын бүтээгдэхүүнийхээ дээж буюу 500 гаруй кг бяслагийг Япон руу гаргасан. Одоо туршилтын шатандаа явж байна...

сүү авдаг. Гэхдээ бид бас өөрийн гэсэн фермтэй. Хажуу талдаа сүү хөргүүрийн төвтэй юм. Тэндээ сүүгээ хүлээн авч хөргөөд анхан шатны боловсруулалтаа туршид сүү нийлүүлэх гэжээ хийдэг юм. Энэхүү төсөл маань үр дүнгээ өгч байгаа. Ингэж цогц байдлаар үйлдвэрлэлээ хөгжүүлж байна, манай компани. “Хотод ойрхон” гэж бид ярьдаг ч Улаанбаатараас 210 км зайтай байрладаг Мөнгөнморьт сумаас л нийслэлийн хэрэглэгчид сүүгээ авдаг шүү дээ. Тийм учраас бид бас хольг бодох хэрэгтэй байна. Өнөөдөр нэг сая үнээний дэлэн дэх сүү саагдахгүй яваад байгаа. Тэр сүүг ашиглах зорилгоор дараагийн алхамуудаа хийж байна.

Ямар төсөл хэрэгжүүлэх бол гээд дараагийн алхам чинь харин сонирхолтой байна. Магадгүй хуурай сүүг эх орондоо хийх гэж байгаа

ч юм билүү. Хуурай сүүний технологийг монголчууд анх гаргасан гэдэг яриа ч бий. Тэр үед цэрэг дайн, аян замд авч явахын тулд сүүгээ хатааж нөөцөлдөг байсан гэж сонсч байлаа. Харин өнөөдөр манай үйлдвэрүүд тухайлбал, “Монфрэш сүү” компани хуурай сүү үйлдвэрлэж байна уу?

Манай фермерүүд томорч, үйлдвэрүүд хөгжиж байж манай улсад хуурай сүү үйлдвэрлэдэг болно. Бидний төвшин хараахан энд хүрээгүй байгаа. Саалтуур, аппарат гээд бүх шат дамжлага гар ажиллагаагүй болох ёстой. Тэгээд эрүүл ахуйн горимоо чанд мөрдөж, гаргасан дүрэм журмаа ягштал биелүүлдэг байх, малын өвчингүй, үхэр тугал цоо эрүүл байх гээд бүхий л зүйлийг хамарч байж цэвэр хуурай сүү үйлдвэрлэнэ. Энэ бол дараагийн шатны асуудал. Хэрэв бид өнөөдөр хуурай сүү үйлдвэрлэвэл эрүүл ахуйн чанар, стандартыг бүрэн хангаж хараахан чадахгүй. Манай компани хуурай сүү үйлдвэрлэх туршилтыг ч хийсэн. Гэтэл нийт фермийн дунд сайн сүү үйлдвэрлэдэг маас маань санасан хэмжээнд хүрээгүй. Хуурай сүү маш их эрчим хүч зарцуулдаг. Ийм учраас хуурай сүү үйлдвэрлэхэд өндөр технологи шаардлагатай. Энэ нь манай нөхцөлд эдийн засгийн үр ашгийг гэдэг тооцооллыг бид гаргасан.

Тийм үү, тэгвэл манай нөхцөлд хуурай сүү үйлдвэрлээд ямар ч ашиггүй гэсэн үг үү?

Импортлоод ч ашиггүй. Яагаад ч юм, манай иргэд хуурай сүүнд ам муутай байдаг. Өнөөдөр долларын ханш өндөр, нэг ам.доллар 2500 төгрөгт хүрчихсэн байгаа. Тэгэхээр ийм өндөр ханшаар хуурай сүү худалдаж аваад шингэлж бүтээгдэхүүн хийхээр ашиггүй. Тэгээд ч валютын ханш бараг 40 хувиар өсчихсөн байхад хуурай сүү худалдаж авах үндэсний үйлдвэр ховор шүү дээ. Харин үүнийхээ оронд малчдаас сүү авч байгаа. Энэ нь ч эдийн засагт эерэг хөшүүрэг болж байгаа юм. Нөгөөтэйгүүр, уг нь хуурай сүүг ад үзэх шаардлагагүй л дээ. Яагаад гэвэл, шингэн сүү байхгүй үед хуурай сүүг хэрэглэх л болно. Шингэн болон хуурай сүү хоёр хоорондоо ялгаатай гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ үндсэн бүрэлдэхүүн хэсэг дэх биологийн идэвхт бодис буюу хүний биед хэрэгтэй бактери, эсүүдийг хуурай сүү ч агуулж л байдаг. Шингэн сүүнд 200 гаруй нэр төрлийн ашигтай бактери агуулж байдаг бол хуурай сүүнд 10 гаруй нь л байдаг юм. Гол ялгаа нь энэ. Гэхдээ үндсэн бүрэлдэхүүн хэсэгт агуулагддаг кальци, уураг нь хуурай сүүнд ч байж л байгаа. Шингэн сүүг хэрэглэхэд үүсдэг нөгөө нэг давуу тал нь хор тайлах, кальци нь хүний биед хамгийн сайн шингэдэг зэргээр бүх үйлчилгээгээ 100 хувь үзүүлж чаддаг.

Ингэхэд тетрапак технологи савалгаанаасаа ямар ялгаатай юм бол. Ойролцоо сонсогддог болохоор хүмүүс их андуурдаг?

UHD технологиор хэт өндөр температурт буюу 137 градуст сүүг буцалгаад маш богино хугацаагаар буюу гуравхан секунд бодис авч ариутгадаг. Энэ технологийг Европын орнуудад маш өргөн ашигладаг. Ийм технологийг боловсруулсан сүүг л сургуулийн үдийн цайнд хэрэглэх заалттай байдаг юм. Учир нь энэ технологиор сүүг боловсруулах явцад шүлхий, бруцеллэзын нян, бактери бүрэн устдаг. Бид сүү нийлүүлэх ийм тогтолцоог нэвтрүүлсэнээр халдвартай сүү хүлээж авахгүй болж байгаа. Иж бүрэн лабораторитой учраас

нийлүүлж буй сүүг шалгадаг. Зундаа Монголд нийт сүүний 80 хувь нь гардаг. Үүнийгээ ашиглахдаа манайхан дандаа зууруу тэвэрлэж, вагоноор зөөвөрлөдөг. Үүн дээр нэмээд мал эмнэлэг хувьчлагдсанаас хойш чанартай эм тарианы асуудал хөндөгддөг болсон. Мөн малдаа вакцин тариулснаас хойш 14 хоногийн дотор сүүгээ нийлүүлэхгүй байх ёстой. Энэхүү эрүүл ахуйн горим зарим малын хотонд зөрчигдөж байна. Зарим нь зөвхөн мөнгө олохын төлөө л явж байгаа нь үнэн учраас малчид үйлдвэрт сүүгээ нийлүүлдэг болж хэвших хэрэгтэй. Мөн төмөр зам, мэргэжлийн хяналт гээд бүхий л байгууллага хамтраад гаргасан дүрэм журмаа биелүүлдэг баймаар байна. Магадгүй өнөөдөр гар дээрээс зарж байгаа шингэн сүүг аваад уусан хүн шүлхий тусгахгүй гэх баталгаа байхгүй. Шүлхий малаас хүнд, хүнээс малд тэр байтугай удам дамждаг аюултай өвчин. Тийм учраас европт шүлхий туссан малыг шууд устгалд оруулдаг. Гэтэл манайд энэ асуудал их эрсдэлтэй төвшинд байна. Улмаар хүнсний аюулгүй байдалд заналхийлж байгаа. Тийм учраас малчид маань үнэгээ саахдаа гараа сайн угааж хэвшихээс эхлээд сүүгээ зөвхөн үйлдвэрт нийлүүлдэг болох хэрэгтэй байгаа юм.

Тетрапак технологиор сүүг хэт өндөр температурт халааж хөргөөд савладаг юм байна. Гэхдээ уламжлалт ойлголтоор бол ахуйн нөхцөлд буюу гэрт сүүг удаан буцалгадаггүй шүү дээ. Нэг удаа л довийлгоод авахад болно. Удаан буцалгавал кальци нь байхгүй болчихно гээд байдаг?

Сүүг ахуйн нөхцөлд хөөрүүлэх нь өөр ойлголт. Сүү 190 градуст жаахан буцалдаг. Гэтэл бруцеллэзын бактери буцалгаснаас хойш таван минут болж байж үхдэг. Үүний дараа л хүн хэрэглэж болно. Харин бидний нэвтрүүлсэн UHD технологийн 137 градуст ариутгасан сүүнд ямар ч эмгэгтөрөгчгүй байдаг учраас бид 100 хувийн баталгаа өгч байгаа. Сүүг үйлдвэрлэлийн аргаар бэлдэнэ гэдэг ойлголт ахуйн нөхцөлөөс арай өөр байгаа биз. Тиймээс манай

иргэд гар дээрээс задгай сүү худалдаж авахгүй байх хэрэгтэй. Ахуйн нөхцөлд уламжлалт арга технологийг үгүйсгэх аргагүй. Сүүг хэт буцалгавал кальци, сүүний уураг нь алга болно гэж хөгшчүүд ярьдаг. Бидний ярьдагаар бол биологийн идэвхт бодис нь байхгүй болохоос л сэргийлээд байна аа даа. Тиймээс UHD технологийн 137 градуст гуравхан секунд болгодог гэдгийг л ойлгох ёстой. Энэ нь дэлхийд шалгарсан технологи. Ингэж маш хурдтайгаар ариутгаснаар сүүн дэх ашигтай биологийн идэвхт бодисуудыг авч үлдэж чадаж байгаа юм. Энэ технологийн давуу тал ерөөсөө л энэ. Дээрээс нь бактеригүй болсон сүү удаан хадгалагдана. Мөн манай тетрапак савалгаа долоон давхар байдаг. Энэ савалгааны онцлог нь гаднах температурыг харьцангуй бага мэдэрнэ. Харин сүүний шимт чанарыг хадгалж чаддаг дэлхийн шилдэг технологи нь тетрапак юм. Өнөөдөр ч нам температуртай бусад компанийн үйлдвэрлэдэг сүү зөвхөн цаасан савлагаатай л байгаа. Тиймээс үүнийг манай компанийн улсдаа хийсэн хамгийн том хөрөнгө оруулалт гэж би хувьдаа боддог.

Сүү, ундаа, бяслаг гээд ер нь танай компани хэчнээн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлж байна вэ?

Сүүн төрлийн 20 орчим бүтээгдэхүүн, шүүсэн төрлийн 30 орчим бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийтдээ 50 орчим төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж байгаа. Сүү нийлүүлэх тогтолцоог бий болгосноор манай компани бүх бүтээгдэхүүнээ шингэн сүүгээр үйлдвэрлээд зогсохгүй анхны экспортын бүтээгдэхүүнийхээ дээж буюу 500 гаруй кг бяслагийг Япон руу гаргасан.

Одоо туршилтын шатандаа явж байна. Өөрөөр хэлбэл, бид дотооддоо үйлдвэрлэдэггүй буюу импортыг орлох бүтээгдэхүүнийг өөрсдөө бий болгох зорилгыг тавьж ажиллаж байгаа. Ингэж дотоодын нөөцөө ашиглах бүрэн боломжтой. Бидэнд бүх зүйл байна. Сүү бий. Ус бий. Тэр бүгдээ бид амжилттай ашиглах ёстой. Гэтэл бид гадаадаас 17 тэрбум төгрөгийн үнэ бүхий 900 тонн бяслаг оруулж ирээд хэрэглэдэг. Харин бид үүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болчихвол энэ чинь импортыг орлох бүтээгдэхүүн мөн биз дээ.

Таны яриа үнэхээр сонирхолтой байна. Эцэст нь Монголын бизнесийн орчин ч бас үнэхээр гайхалтай юм даа гэж өөрийн эрхгүй дуу алдмаар юм. Бяслаг экспортолох туршилтыг танай компани хийж байгаа нь Монгол Улсын нэг иргэний хувьд надад маш их таалагдаж байна. Гэхдээ ямар ч бодлого зохицуулалтгүй замаар ямар зоригтой явагдаж юм бэ. Өнөөдөр манайд цөөнгүй сүүний үйлдвэр бий. Дээрээс нь гар дээрээс худалдаалж байгаа задгай сүүнүүд ч байна. Гэтэл дэлгүүрийн лангуун дээр импортын сүү байж л байдаг. Ер нь манай улсын сүүний зах зээлийн хэдэн хувийг импортын сүү эзэлдэг юм бол. Сүүний асуудлаа бүрэн шийдэж чадаагүй улсад экспортын бяслагийг зөвхөн бизнесмэн хүн л ярьж чадах юм даа. Үнэхээр гайхалтай?

1990-ээд оноос үйлдвэрүүд зогсч, манай улс үйлдвэрлэгч компанигүй болсон шүү дээ. Энэ үед иргэдийн ярьдагаар шар сүү буюу ОХУ-аас импортлодог сүү дэлгүүрийн лангуугаар дүүрэн байлаа. Тэгээд 1997 оноос хойш л үндэсний үйлдвэрүүд хөгжиж, “Монфрэш сүү”, “Сүү” зэрэг компаниуд ашиглалтад ороод одоо бол импортын сүү манай зах зээлийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байгаа. Бусад буюу 90 хувийг дотоодын үйлдвэрлэгч нар эзэлж байна. Гэхдээ энэ дунд байгаа задгай сүү худалдаалагч нарыг болиулах хэрэгтэй. Ер нь хүнсний аюулгүй байдалд харанга дэлдсэн ийм үзэгдэл UHD технологи хөгжсөн орчин үед байх нь зөв биш шүү дээ.

# НИЙГЭМ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## АНАГААХААР ОВОГЛОСОН ХҮН БҮРИЙН ЭНГЭРТ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН ГЯЛАЛЗАХ НЬ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Н.БАТЗАЯА

Улсын нэгдүгээр эмнэлгийн зүүн талд байрлах нэгэн сургуулийн урдуур өнгөрөх болгонд өөрийн эрхгүй бахархах сэтгэл төрнө. Тус сургуулийн орчин, сургалтын тоног төхөөрөмж, багш нарын заах арга барилыг харахаар оюутнуудад нь битүүхэн атаархдагийг нуух юун. Магадгүй АШУУИС-д тасралтгүй үргэлжилж буй бүтээн байгуулалтын ажлыг үзсэн харсан, сонссон хүн бүрт энэ их дэврүүн сэтгэл төрөх биз ээ. Их сургуулийн нэгдсэн эмнэлэг, олон улсын стандартад нийцсэн номын сан, гарааны компаниуд гээд дурьдал олон бүтээн байгуулалтын ажил АШУУИС-иар овоглоно. Түүнээс гадна Ази, Номхон далайн баруун эргийн бүсийн 100 шилдэг их, дээд сургуулийн нэг болох том зорилго өвөртлөн ажиллаж буй энэ сургууль Монгол Улсын анагаахын салбарт хүчин зүтгэх эмч, мэргэжилтнүүдийн 90 гаруй хувийг бэлтгэн гаргаж байна. Тэгвэл 75 жилийн түүхтэй тус сургуулийн төдийгүй түүхэнд тэмдэглэгдэх нэгэн үйл явдал өчигдөр болж өндөрлөв. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар АШУУИС-ийг төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагналаа. Төрийн дээд одон гаргуулах ёслолын үйл ажиллагаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан, БСШУС-ын дэд сайд Ё.Отгонбаяр, БСШУС-ны Шинжлэх ухаан технологийн газрын дарга, АШУУИС-ийн удирдах зөвлөлийн дарга Т.Ган-Эрдэнэ, АШУУИС-ийн Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал Н.Сүмбэрзул, АШУУИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал Б.Мөнхбат, Монгол Улсын ардын багш, хүний гавьяат эмч, доктор, профессор Г.Цагаанхүү, Монгол Улсын ардын багш, хүний гавьяат эмч Х.Гэлэгжамц, Монгол Улсын ардын эмч, хүний гавьяат эмч Ж.Баасанхүү болон хамтран ажилладаг гадаадын төлөөлөгчид, багш оюутан сурагчид оролцлоо. Энэхүү үйл ажиллагааг нээж, АШУУИС-ийн Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал Н.Сүмбэрзул “Бид бүхний төрөлх их сургуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасанд анагаахаар овоглуулсан хүн бүхэн, хүн ардынхаа эрүүл мэндийн манаанд өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж буй эмч мэргэжилтнүүд, энэ сургуультай амьдралаа холбон

айсуй цагийн авралын бурхадыг бойжуулан гаргаж буй эрдэмтэн, профессор багш нарын өмнөөс туйлын баяртай байна. Аливаа хөгжил дэвшил уламжлал шинэчлэлт нь өнгөрсөн, одоо, ирээдүйн бат холбоонд суурилан явагддаг жамтай. Өнөө үеийнхнийг өсгөн хүмүүжүүлж, хөгжлийн энэхүү өндөрлөгт хүрэх суурийг багтгай тавьсан, бидний хайрлан хүндэтгэдэг эрдэмтэн багш нар, мэргэжлээрээ овоглуулсан анагаахын бурхан эмч нар, ахмад үеийнхэндээ гүнээ талархаж, та бүхнийг дурсан хүндэтгэж мэхийн ёсолъё. Өнгөрсөн зууны эхэнд шинэ насалт 50 хүрэхгүй байсан хагас сая хүнтэй монгол орон зарим судлаачдын үзсэнээр мөхөж буй үндэстэнд тооцогддог байлаа. Тэгвэл өнөөдөр Монголчууд гурван сая болтлоо өсчээ. Мөн дундаж насалт 70 хүрч, эх, хүүхдийн эндэглэл эрс буурч, мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтыг биелүүлсэн дэлхийн цөөхөн орны тоонд багтлаа. Мөн эх орныхоо өнцөг булан бүрт хүрсэн эрүүл мэндийн тогтолцоотой, олон улсын төвшинд ажиллах эмч мэргэжилтнүүдтэй ирээдүйтэй итгэлтэй эрүүл чийрэг эрдэм боловсролтой иргэдтэй, дэлхийн нийгэмлэгт өөрийн байр сууриа баттай эзэлсэн орон болон хөгжсөн нь яах аргагүй эдгээр хүмүүсийн маань гавьяа юм. Бид 2024 он гэхэд Ази, номхон далайн баруун эргийн бүсийн шилдэг 100 их, дээд сургуулийн нэг болох эрхэм зорилго тавин ажиллаж байна. Их сургуулийн хамт олныг шагнасан энэхүү төрийн дээд шагнал нь эрхэм зорилгоо биелүүлэн бүсийн шилдэг их сургууль болох итгэлийг улам батжуулж, сэтгэлийн урмыг бидэнд хайрлалаа” гэв. Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан гардуулав. Тэрбээр “Монгол Улсын их сургуулийн Хүн эмнэлгийн факультетийн суурин дээр үндэслэн байгуулагдсан АШУУИС-д эдүгээ 21 мэргэжлээр 13 мянган оюутан, төрөлжсөн нарийн мэргэжлээр 100 гаруй, сувилалын мэргэжлээр 10 гаруй, магистрантурт 700 орчим, докторантурт 160 гаруй оюутан суралцаж байна. Орчин үеийн сайн багш, судлаачид ажилтнуудын амжилтын хүчээр та бүхэн энэ бахархам түүхийг бүтээсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн

зарлигаар олгож буй төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон бол монгол хүний эрүүл мэндийн төлөө зүтгэсэн хүн бүрийн энгэрт гялалзах одон юм. Монгол хүний эрүүл мэндийг сахин хамгаалах эмч, сувилалчдын бэлтгэж буй эрдмийн их уурхай болсон сургуульд гүн хүндэтгэл илэрхийлэ” гэлээ. Монголын анагаах ухааны салбарт түүхийн нэгэн хуудсыг нэмсэн Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон бол тус сургуультай ажил, амьдралаа холбосон хүн бүрийн хөдөлмөрийн үр шим юм. Энэ өдрөөс эхлэн АШУУИС-ийн бүхэл өнөөдөр Монголчууд төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон гялалзана гэдгийг ёслолын үйл ажиллагаанд оролцсон хүмүүс онцолж байлаа. Энэ үеэр Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон гардуулах ёслолын үйл ажиллагаанд оролцогчдын төлөөлөлтэй цөөн хором ярилцаж, сэтгэгдлийг нь сонслоо.

Ё.Отгонбаяр: Үе үеийн багш, ажилтнуудын хөдөлмөрийн төр үнэлж байна

/БСШУС-ын дэд сайд/

-1932 онд Монгол Улсын их сургуулийн Хүн эмнэлгийн факультет гэж байгуулагдсан. Энэ сургууль 1962 онд анагаах ухааны дээд сургууль болон өргөжиж байлаа. Өнөөдөр эрүүл мэндийн салбарын боловсон хүчний 90 гаруй хувийг бэлтгэн гаргаж, долоон бүрэлдэхүүн, гурван салбар сургуультай, 1000 гаруй багш, сурган хүмүүжүүлэгч, 12 мянга гаруй оюутантай том сургууль болон өргөжжээ. БСШУС-аас болон Засгийн газраас дээд боловсролыг чанаржуулах бодлого баримталж байгаа. Уг бодлогын хүрээнд АШУУИС Ази, Номхон далайн баруун эргийн тэргүүлэх 100 сургуулийн нэг болох зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Мөн Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар энэ сургуулийн харьяа эмнэлэг баригдаж байна. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон зөвхөн энэ сургуульд өгч байгаа шагнал биш юм. АШУУИС-д ажиллаж ирсэн үе үеийн багш, сурган хүмүүжүүлэгч, ажилтан, одоо ажиллаж байгаа хүмүүсийг урамшуулж, тэдний хөдөлмөрийг төрөөс үнэлж байгаа нэг хэлбэр юм.

Т.Ган-Эрдэнэ: Гадаад харилцаагаа өргөжүүлэн зарим үзүүлэлтээрээ олон улсын төвшинд хүрсэн

/БСШУС-ны Шинжлэх ухаан технологийн газрын дарга, АШУУИС-ийн удирдах зөвлөлийн дарга/

-АШУУИС байгуулагдсаны 75 жил, дээд боловсролтой анхны эмч төрөн гарсаны 70 жилийн ой тохиосон түүхт мөчид Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдлаа. Монгол Улсын их сургуулийн Хүн эмнэлгийн факультетийн эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр нь нийгмийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж, суралцах оюутнуудын тоо жилээс жилд нэмэгдэн факультетийн үүргээ нэр төртэй биелүүлсэн учраас МАХН-ын Төв хорооны 1961 оны 179 дүгээр тоот тогтоол, БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1961 оны 441 тоот тогтоолоор Монгол Улсын их сургуулийн Хүн эмнэлгийн факультетийг Анагаах ухааны дээд сургууль болгон өргөтгөх түүхэн шийдвэр гарч байлаа. Энэ хугацаанд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд гадаад, дотоодын хамтын ажиллагаа өргөжиж, судалгаа, сургалтын орчин эрс сайжран зарим үзүүлэлтээрээ

олон улсын төвшинд хүрсэн. Мөн санхүү эдийн засгийн чадавх нэмэгдсэнээр бүтээн байгуулалт эрчимжин, эрдэм шинжилгээний ажил санхүүжиж, суралцагчиддаа сургалтын тэтгэлэг олгодог болсон.

Г.Цагаанхүү: Залуу үеийнхэнд урам хайрлаж, итгэлийг нь бадраасан шагнал

/Монгол Улсын ардын багш, хүний гавьяат эмч, доктор, профессор/

-Юуны өмнө үе үеийн эрдэмтэн багш, оюутан сурагчиддаа энэ сайхан баярт өдрийн мэндийг хүргэе. Энэ цаг мөчид түүхийн хуудсыг эргүүлэхэд манай сургуулийн анхны суурь 1942 онд тавигдаж байлаа. Тэр үед анагаах ухааны салбарын үндэс суурийг тавьсан анхдагчууд, алдаргунуудын хөдөлмөрийн үр дүн шингэсэн шагнал. Нөгөө талаас манай сургуулийн үе үеийн захирал, удирдлага, хамт олны хөдөлмөр шингэсэн шагналыг бид өнөөдөр хүлээж авлаа. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор АШУУИС-ийг шагнасан нь манай сургуулийг төгсөж байгаа оюутан залуус, цаашид энэ сургуульд ажиллах залуу үеийнхэнд урам зориг хайрлаж, тэдний итгэлийг бадраасан сайхан үйл явдал

боллоо. АШУУИС сүүлийн үед гадаад, дотоодын хүрээнд нэр хүнд нь өсч байгаа. Нэг жишээ дурьдахад, сургалтын орчин сайжирлаа. Номын сан, эко цогцолбор баригдлаа. Түүнээс гадна салбар сургуулиудад бүтээн байгуулалтын ажил өрнөж, тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагаа нь эрчимтэй өргөжиж байна.

Б.Хатантуул: Цаашид улам хичээн суралцах ёстойгоо ойлголоо

/Эт зүй био анагаахын сургуулийн IV курсийн оюутан/

-Энэ сайхан түүхэн мөчийг хамт хуваалцсанддаа маш их баяртай байна. Би сургуулиа нэг гэр бүл, нэг өрх гэж боддог. Аав, ээж нар хүүхдээ өлгийдөн авч, өсгөж хүмүүжүүлдэг шиг сургуулийн маань баг нар биднийг анагаахын эрдэмд сурган хүмүүжүүлж, хариуцлагатай эмч мэргэжилтэн болох үүд хаалгыг минь нээж өгдөг. Багш нараараа маш их баярладаг. Мөн сургууль минь энэхүү эрхэм хүндтэй шагналыг авсанд маш их баярлаж байна. Цаашид улам хичээн суралцаж, хариуцлагатайгаар ажиллах ёстой юм байна гэдгийг ойлголоо. Багш нартаа, үе үеийн төгсөгчид, сургуулийнхаа удирдлагуудад дахин дахин баярлалаа гэж хэлье.

### ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

2017.07.06

**Тендер хүлээн авах хугацаа сунгах тухай**

Тус газраас зарласан НХААГ-17/0165 дугаартай “Автобусны эцсийн буудлын цогцолбор барилга, зам талбайн тохижилтын зураг төсөв /нэг байршилд холбох/ боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн дэлгэрэнгүй жагсаалт бүрдүүлэхээр зөвлөхийн мэдүүлгийг 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10 цаг 00 минут хүртэл хүлээн авах байсан боловч тус өдөр Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалт явагдах болсон тул хойшлогдож 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 09 цаг 00 минут болсныг мэдэгдэж байна.

## ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ



## “СУРГУУЛИЛТ ИРЭЭДҮЙН АВАРГЫГ БҮТЭЭДЭГ”

Б.ДАВАА

Энэ зураг 60 дахь удаагийн дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2017” наадмын өдөр тутмын амьдрал төрөлд дэд байр эзэлжээ. Тус тэмцээнд дэлхийн 125 орны 5034 зурагчин 80408 бүтээлээ сойсноо БНХАУ-ын гэрэл зурагчин Ван Тай Жуны гимнастикийн сургуулийн охидын чанга хатуу

бэлтгэл сургуулийг харуулсан эл зураг шүүгчдээ өндөр үнэлэлт авч, шилдгээр шалгарсан нь энэ аж. Зургийг 2016 оны долдугаар сарын 15-нд Жянсю мужийн Шюйжоу хотод авчээ. БНХАУ-ын хэмжээнд нийтдээ 2000 спортын чиглэлийн сургууль байдаг аж. Тэдгээрийн 95 хувиас нь олимпын аваргууд төрөн гарсан байдаг байна. Тиймдээ ч ирээдүйн олимпын аваргыг бэлддэг гэдэг утгаараа маш хатуу чанга дэглэм дор спортын бэлтгэл сургуулийг

хийлгэдэг байна. Дээрх зурагт гимнастикийн сургуулийн охид үдээс хойш өдөр бүр 30 минутын турш хуруун дээрээ зогсох дасгал хийдэг бөгөөд бэлтгэлийнх нь үеийн нэгэн агшин гэрэл зурагт ийн дүрслэгджээ. Гэвч, сүүлийн үед зарим эцэг эхчүүд хүүхдээ хүнд хүчир дасгал сургуулилт хийлгэхийг төдийлөн зөвшөөрдөггүй болсон гэнэ. Үүнтэй холбоотойгоор цөөн тооны спортын сургуулиуд хаалгаа барьж эхэлсэн байна.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр 20  
Шөнө 13

Нөгөөдөр  
Өдөр 24  
Шөнө 13

Өдрийн  
Зурхай

ЗУНЫ ДҮНД УЛААН  
МОРЬ САР ДӨРВӨН  
НОГООН МЭНГЭТЭЙ ХӨХ  
МОРЬ ӨДӨР

Наран ургах шингэх: 05.00-  
20.52

Үс засуулбал: Жаргал ирнэ



Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие эхрийлүүштэй. Хувацас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал айлшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэтцэл болох, хэрэг дуугарвал зочид ирэх, тагнай заагнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хол татвал үзэсгэлэн болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

## ОДДЫН АМЬДРАЛ

### “Нарны үр саг” КИНОНЫ ОДОД ХУРИМЛАНА



Ази тивийг байлдан дагуулж байсан Өмнөд Солонгосын “Нарны үр сад”

телевизийн цуврал киноны гол дүрийн жүжигчид болох Сон Жүн Ки, Сон Хе Кё нар ирэх аравдугаар сард гэрлэх болсноо хэдхэн цагийн өмнө зарлажээ. Одоо 32 настай Сон Жүн Ки, 35 настай Сон Хе Кё нар “аравдугаар сарын сүүлийн өдөр” нэг гэрт орно гэдгээ хамтарсан мэдэгдэлд өгүүлсэн байна.

“Олон фэнүүддээ гэнэтийн мэдээ дуулгаж байгаадаа уучлал гуйж байна. Учир нь гэрлэлт бол бидний амьдралын маш чухал үйл явдал тул бид өнөөдрийг хүртэл нууцалж, болгоомжилж байсан юм” хэмээн одууд мэдэгдэлдээ бичжээ. Одоогоор хуримын тов хараахан гараагүй байна.

## МЭДЭЭЛЭЛ

### Одонтой ээжүүд саналаа өгөхийг уриалав

Б.БОЛОРТУНГАЛАГ

“Цагаан сонгууль”-ийн хувьсгал хийхийг эсэргүүцэж “Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтандаа өргөнөөр оролцохыг уриаллаа. “МАХН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж өрсөлдсөн С.Ганбаатар сонгогчдод хандаж “хоёр

дахь шатны санал хураалтад “Цагаан сонгууль”-ийн хувьсгал хийхийг уриалсан явдал харамсаж “Алдарт эхийн одонтой ээжүүдийн холбоо” ТББ-аас мэдэгдэл гаргахад хүргэсэн” гэж холбооны тэргүүн Б.Мөнхтуяа хэллээ. Төрийн тэргүүнээ сонгох сонгуулийн ирцийг саармагжуулан сарниулах, сонгуулийн

санал хураалтыг хүчингүйд тооцуулах улмаар төрийн дээд удирдлагын тогтолцоог алдагдуулж, хувийн эрх ашгийн үүднээс улс төрийн тэмцэл хөдөлгөөнд уриалж байгаа “Цагаан хувьсгал” гэгчийг “Алдарт эхийн одонтой ээжүүдийн холбоо ТББ-аас эсэргүүцэж саналаа өгөхийг уриаллаа.

### Маргааш зах, худалдааны төвүүд ажиллахгүй

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал авахтай холбогдуулан зарим арга хэмжээний тухай захирамж гаргалаа. Захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт үйл

ажиллагаа явуулж байгаа хүнс, барилгын болон мод, модон материал, түүхий эд, техникийн зах, худалдааны төвүүдийн тухайн долоо хоногийн амралтын өдрийг сонгуулийн санал авах өдөр буюу долдугаар сарын 7-ны өдөрт шилжүүлэхийг аж ахуйн нэгж, байгууллагын

удирдлагуудад үүрэг болгов. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, иргэдийн дахин санал хураалтад идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд тус захирамжийн зорилго оршиж байгаа юм.

## Бидэнд тохиолдсон



ХҮНДЭХН ХӨГТЭИ  
ЯВДЛУУД

С. Ундармаа



Төрөх гэснээс нэг эгч төрөх гээд өвдөөд алингаа алдаж л дээ. Тэгснээ эмчийнхаа өрөөний үүдэнд очоод “Эмчээ би кесерова хагалгаагаар төрчихье, үхлээ” гээд л гуйгаад зогсож байсан чинь нүдэнд нь хүлээн авахын цонхоор нөхрийнх нь толгой харагдсан байгаа юм. Эгч шууд л уйлсан гэсэн. Тэгээд нөхөртэйгөө уулзаад зогсож байтал хамт нэг өрөөнд байсан эмэгтэй нь бас өвдчихсэн явж байсан чинь нөхөр нь нөгөө хүлээн авахын цонхоор шагайгаад “яаж байна, хайраа” гэсэн чинь “май” гэсэн гэж байгаа. Ха ха ха.



## ЭРХТЭН СИСТЕМАДЭЭ ИХ ЦӨВӨРЛӨГӨӨ ХИЙГЭЭРЭЙ

үүсэх нэг шалтгаан болж байна. Тиймээс таньд UNICITY CLEANSE сэвэрлэгээний төгс бүтээгдэхүүнийг таньд санал болгоё.

Шимэгч, бактери, хог хаягдлаас биенийг сэвэрлэснээр гарах үр дүн:

- Ядрахаа болино
- Хөгшрөлтөөс сэргийлнэ
- Харшилд өртөхгүй
- Өтгөн хатах, гүйлгэх, шамбарам зэргээс ангижирна
- Хэт таргалах, Хэт турах,
- Гэдсээрээ бүдүүрэхээс ангижирна
- Дархлаа сайжирч, бактери вирусын халдварт өртөхгүй
- Тууралт загатнаа, батга, хуурайшилт зэрэг арьсны эмгэг засаж, өнгө сайжруулна

- Хоолны шингэц сайжруулна
- Шээс дасагны зовиургүй болно
- Амьсгал биеийн үнэр тааламжтай болно
- Анхаарал төвлөрөл, ой тогтоомж,
- Арьс чангаруулна
- Сэтгэн бодох чадвар сайжирна.
- Архи, тамхины донтолтгүй болно

**Давуу тал:** Манай бүтээгдэхүүн нь клиник судалгаа хийж батлагдсан албан ёсны зөвшөөрөл, гэрчилгээтэй 100 хувь ургамлын гаралтай дэлхийд танигдсан бүтээгдэхүүн билээ.

**Жич:** АНУ-ын соронзон долгионы аппаратаар эрхтэн системийн 37 үзүүлэлт 250 зүйлээр хямд оношилж байна.

АНУ –ын 114 жилийн хөгжилтэй UNICITY компанийн ургамлын гаралтай, сэвэрлэгч тэжээл өгөгч UNICITY CLEANSE бүтээгдэхүүнийг уншигч таньд танилцуулж байна. Энэхүү бүтээгдэхүүн нь монголчуудын толгойн өвчин болоод буй өтгөн хатаал болон таргалалтын асуудлыг бүрэн шийдэж, маш сайн үр дүн гаргаад байгаа. Хүний гэдсэнд олон жил хуралдан тогтож чулуужсан 5-40 кг баас шаваадас, 130-аад төрлийн шимэгч үүрлэж байна.

Нэг хүнээс доод тал нь 4-5 төрлийн шимэгч илэрч байгаа нь аюулын харанга дэлдэж байна. Шимэгчийг биеэс гадагшлуулахгүй бол яаж ч жин хассан буцаад жин нэмэгддэг. Шимэгч паразитууд өөрөөсөө хор ялгаруулж хүнийг үхэлд хүргэх аюултай бөгөөд хорт хавдар

Манай хаяг: 25-р эмийн сан Кёкүшю цамхаг 7 давхарт 706 тоот. Утас: 99003733, 88961635. Зөвлөгөө мэдээлэл, хүргэлт үнэгүй.